

Голомт Секюритиз ҮЦК ХХК нь 2012 онд Монгол улсын шилдэг банкуудын томоохон төлөөлөл болох Голомт банкны 100% -ийн хөрөнгө оруулалттай охин компани болон байгуулагдсан бөгөөд брокерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг хөрөнгө оруулагч, дотоод гадаадын харилцагч, түншүүд, хамтран ажиллаж байгаа байгууллагууддаа чанарын өндөр түвшинд хүргэн ажилладаг юм.

Манай компани олон улсын тэргүүлэх зэргийн санхүүгийн байгууллагуудтай хамтран ажилладаг ба Монголын Хөрөнгийн биржийн гишүүн төдийгүй үйлчлүүлэгчиддээ дэлхийн бүхий л томоохон биржүүдээр арилжаа хийх боломжоор ханган ажиллаж байна.



Үнэт цаасны арилжаа

Монголын хөрөнгийн бирж болон олон улсын бүхий л томоохон биржүүд дээр арилжаа хийх



Хөрөнгө оруулалтын зөвлөх

Үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн бүхий л төрлийн мэргэжлийн зөвлөгөө



Андеррайтер

Хувьцааны болон өрийн зах зээл дээр хөрөнгө босгох, IPO хийх үйлчилгээ



Судалгаа

Дотоодын болон олон улсын компаниудын бүрэн судалгаа хийх

Тойм:

- Монголын Хөрөнгийн Бирж болон олон улсын зах зээл дээр арилжаа хийх боломжтой интернет арилжааны системийг анх нэвтрүүлсэн
- Анхны бүрэн даатгагдсан компанийн бондыг дотоодын зах зээл дээр амжилттай арилжаалсан ба илүү захиалга 5 дахин их байв
- Анхдагч болон хоёрдогч зах зээл дээр Засгйн газрын болон компанийн үнэт цаасны арилжаа эрхлэгч шилдэг брокер дилерийн компани
- Олон сая долларын дээш уул уурхайн нэгтгэл болон авах (M&A) төслийн магдлан шинжилгээ (due diligence)-г хийж гүйцэтгэсэн

Давуу тал:

- Голомт банкны 20 жилийн туршлага дээр суурилсан судалгаа, шинжилгээ болон дотоодын томоохон аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан олон жилийн харилцаа
- Лондонд төвтэй дэлхийн хөгжиж буй орнуудын зах зээл дээр дагнан ажилладаг, салбартаа тэргүүний хөрөнгө оруулалтын банк болох First Frontier Capital LLC-тай хамтын ажиллагааны гэрээтэй ба тус банкаар дамжуулан судалгаа шинжилгээ хийх гадаадын хөрөнгө оруулалт татах зорилгоор ажиллаж байна
- Олон жилийн туршлагатай мэргэжилтнүүдийн дотоодын болон олон улсын компаниудын судалгаа
- Монголын Хөрөнгийн Бирж болон олон улсын доор дурьдсан биржүүдэд арилжаа хийх боломжтой:
 - New York Stock Exchange
 - NASDAQ
 - London Stock Exchange
 - Hong Kong Stock Exchange
 - Singapore Stock Exchange
 - Frankfurt Stock Exchange
 - Toronto Stock Exchange
 - Canadian Stock Exchange
 - Australian Stock Exchange
 - Tokyo Stock Exchange
 - Korea Stock Exchange



Үйлчилгээ:

- Андеррайтинг
- Хувьцааны санхүүжилт
- Өрийн бүтэцжүүлэлт
- Нэгтгэл болон авах
- Магадлан шинжилгээ хийх

Бүтээгдэхүүн:

- Дотоодын болон олон улсын хувьцаа
- Бонд болон тогтмол хүүтэй хэлцэл
- Хадгаламжийн бичиг болон мөнгөний зах зээлийн сан

- Голомт Секюритиз ҮЦК ХХК дотоодын болон олон улсын компаниудад хөрөнгө босгох, хөрөнгө оруулалтын зөвлөх, санхүүгийн зөвлөхийн үйлчилгээг харилцагчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэж байна. Үүнд:

Байгууллагын нэр	Үйлчилгээ
1. Бодь Интернэшнл ХХК	Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх, зах зээлийн судалгаа
2. Чингис Шар Айраг ХХК	Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх, зах зээлийн судалгаа
3. Монфреш ХХК	Санхүүгийн зөвлөх
4. АБТС ББСБ ХХК	Санхүүгийн зөвлөх
5. New Caml Mongolia LLC	Санхүүгийн зөвлөх
6. Mongolia opportunities Partners	Санхүүгийн зөвлөх
7. Wagner Asia Equipment LLC	Санхүүгийн зөвлөх
8. Дорнын Хүдэр ХХК	Санхүүгийн зөвлөх
9. First Frontier Capital Limited	Хөрөнгө оруулалтын зөвлөх
10. Цэцэнс Майнинг энд Энержи ХХК	Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх, зах зээлийн судалгаа
11. Номадс Хоспиталити ХХК	Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх, зах зээлийн судалгаа
12. Номадс Фүүд Энд Бевережис ХХК	Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх, зах зээлийн судалгаа
13. Нью Тур Сафарис ХХК	Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх, зах зээлийн судалгаа
14. Голомт Файнэншил Групп ХХК	Санхүүгийн шинжилгээ, хөрөнгө оруулалтын зөвлөх
15. Uranium Industry LLC	Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх, зах зээлийн судалгаа
16. Эрчим Инженеринг ХХК	Компанийн бонд гаргах андеррайтерийн үйлчилгээ, анхны бүрэн даатгагдсан бонд Андеррайтерийн үйлчилгээ
17. Төрийн Орон Сууцны Корпораци ТӨҮГ	Андеррайтерийн үйлчилгээ
18. Хаан Банк	Санхүүгийн зөвлөх
19. National Securities LLC	Санхүүгийн зөвлөх

- Голомт Секюритиз ҮЦК ХХК олон улсын шилдэг программ хангамж, мэдээллийн хэрэгслийг ашиглан шуурхай үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

Программийн нэр	Зориулалт
1. Bloomberg Anywhere	Санхүүгийн мэдээлэл, дата, судалгаа, шинжилгээ, зах зээлийн мэдээг хамгийн шуурхай авах
2. MIT Trader	Дотоод зах зээлд арилжаа гүйцэтгэх
3. MIT Millennium Depository	Харилцагчийн мэдээллийн сангийн найдвартай, аюулгүй хадгалалт
4. Nomura Research Institute - Back Office System	Харилцагчийн арилжаа болон үнэт цаасны мэдээллийн сангийн найдвартай, аюулгүй хадгалалт
5. Omnesys - Nest Trader, Web client	Дотоод зах зээлд арилжаа гүйцэтгэх
6. First Shanghai - QGT platform	Олон улсын зах зээлд арилжаа гүйцэтгэх

- Олон улсын болон дотоодын хөрөнгийн зах зээл дээр олон жилийн туршлагатай баг үйлчлүүлэгч, харилцагчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.
 - Э.Амарбаясгалан | Гүйцэтгэх захирал
2014 онд Голомт Секюритиз ҮЦК ХХК-д Гүйцэтгэх захиралын албан тушаалд томилогдохоос өмнө АНУ-ын Visa, Pillsbury компаниудад санхүүгийн ахлах шинжээч, Ньюком групп болон Голомт банкинд удирдах албан тушаал хашиж байсан. Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.
 - Д.Мөнхбат | Хөрөнгө оруулалтын менежер
Олон улс болон дотоодын зах зээлд 8 жилийн туршлагатай дилер, санхүү, хөрөнгө оруулалтын шинжээч өмнө нь ResCap, Өндөрхаан инвест болон Confedence аудит зэрэг компаниудад ажиллаж байсан, математикч, эдийн засаг мэргэжилтэй.
 - А.Телнар | Хөрөнгө оруулалтын менежер
Олон улс болон дотоодын төрийн, хувийн байгууллагуудад санхүү, эдийн засгийн шинжилгээний туршлагатай, өмнө нь Японы Мизухо Банк, Эрдэнэс Оюу Толгой ХХК, Таван Богд Трейд зэрэг компаниудад ажиллаж байсан. Бизнесийн удирдлагын болон эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.
 - Б.Намуугэрэл | Санхүү, хөрөнгө оруулалтын шинжээч
Тайван улсад олон улсын санхүүгийн чиглэлээр төгссөн, өмнө нь VFAS зөвлөх үйлчилгээний корпорацид санхүүгийн шинжилгээ хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан. Корпорацийн санхүүгийн чиглэлээр мэргэшсэн.
 - Г.Золжаргал | Брокер, ерөнхий нягтлан бодогч
Компанийн төслүүдийн хүний нөөц, нягтлан бодох бүртгэлийн шинжилгээг хариуцан ажилладаг ба СЭЗДС-д магистрийн болон Мэргэшсэн Нягтлан Бодогчдийн Институтээс мэргэжлийн нягтлан бодогчийн зэрэг тус тус горилж байгаа.